ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Аймгийн аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын 2019 оны танилцуулга

www.Khuvsgul.nso.mn

АГУУЛГА

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ
I. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ
II. ХАМРАХ ХҮРЭЭ
III. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
IV. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭР
IV.1 НҮҮРС ОЛБОРЛОЛТ
V. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ
V.1 ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ
V.1.1 Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
V.1.2 Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
V.1.3 Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ
VI. ХУДАЛДААНЫ САЛБАР
VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
VIII.ДҮГНЭЛТ
АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Хөвсгөл нутаг нь хувьсгалын өмнөх Халхын гурван аймаг, Шавь зэрэг дөрвөн газрын уулзвар нийлсэн онцлог хязгаар байв. Хөвсгөл аймгийн олон ястны дотор гар үйлдвэрлэл бие даасан салбар болж хөгжөөгүй байсан тул зөвхөн гэр зуурын туслах үйлдвэрлэлийн шинжтэй байжээ. Хүмүүс мал маллахын завсарт босон суун хийдэг өөрсдийн ойр зуурын хэрэгцээний зүйлийг бэлтгэх зорилготой байсан. Гар урлалын ажилд бас мэргэжлийн ялгавар байжээ. Гэрийн мод хаалга, тооно, унь, хана хийх, эмээлийн мод, тэрэг чарга хийх, модон сав суулга хийх, авдар сав, шүүгээ модон ор, ширээ сандал бэлтгэх, байшин барилга барих хүртэл бүхий л ажлыг модны мужаан хүмүүс гүйцэтгэж, тэднийг мод цавчирдана хэмээн данс бүртгэлд тэмдэглэж XVIII-XIX зууны үед Хөвсгөл нутагт олон тооны модчин, тэрэгчин, эмээлчин, уран сийлбэрчид, байшин барилга, дуган сүм урлаачид төрөн гарч эд зүйлийг бүтээж босгож байжээ. Мөн урчууд модоор талхи, хэдрэгэ, эмээл, янгирцаг, эрвээлж, дөрөө, эргүүлэг, чагт, тэмээний шат, үхрийн буулга, сааль, нум сум гэх зэрэг олон зүйл хийж байжээ.

1936 оны 1 сард Хөвсгөл аймагт гар үйлдвэрийн хоршооллын төлөөлөгчийн газар байгуулагдаж, 1937 онд Бүрэн, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Рашаант сумдад 82 урчуудтай гэрээ байгуулж модон тэрэг, гэрийн мод, гутал зэрэг эд бараа захиалан үйлдвэрлүүлж бүтээгдэхүүнээ борлуулан ашиг олж эхэлжээ.

Хөвсгөл аймагт аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд их анхаарал тавьж ЗХУ-ын тусламжаар 1961 оны 6 сарын 27 нд Мөрөн хотод гурилын үйлдвэр ПТС-1200 маркийн илчит цахилгаан станц, 6-Ч-36/45 маркийн дизель станц бүгд 830 квт-ын хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтөй ажиллаж, 1966 оны 8 сараас биеэ даасан эрчин хүчний үйлдвэр болон хөгжжээ. 1966 оны 3 сард Эгийн голын нүүрсний уурхай нээгдэж ажиллав. Аймгийн үйлдвэрлэлийн хоршооллын суурин дээр 1972 оны 3 сард Мөрөн, Хатгал, Цагаан-Үүр, Тариалангийн модон үйлдвэрлэлийн тасаг, ойн аж ахуйн мод бэлтгэлийн бригад зүсмэлийн тасгийг нэгтгэн Мөрөн хотын мод боловсруулах үйлдвэрийг байгуулжээ. Мөн 1979 онд Хатгалын модны үйлдвэрлэлийн цех, 1980 онд Мөрөнгийн гэрийн мод, гэр аж ахуйн модон эдлэл үйлдвэрлэх цехийг ашиглалтанд оруулжээ. Мөн 1972 онд Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар байгуулагдав. 1990 онд аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 7.5 дахин өссөн дүнтэй байсан боловч үйлдвэрлэлийн чанар, үр ашгийг дээшлүүлэх бололцоог ашиглаж чадаагүй дутагдал байсаар байв.

Аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 1990 онд 81.7 сая төгрөг байсан бол 2000 онд 2357.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2358.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөц харахад 37.9 дахин нэмэгдсэн мэт харагдах боловч энэ хугацаанд мөнгөний ханшийн уналтыг хамгийн багаар 200 дахин унасан гэж үзвэл 2000 онд үйлдвэрлэж гаргасан аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 1990 оноос өмнөх үеийн төгрөгийн ханшаар бодож үзвэл 11.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж 1990 оны түвшингөөс 7-8 дахин буурсан байна.

1994 оны байдлаар Хөвсгөл аймагт үйлдвэрлэл үйлчилгээ явуулахаар 600 гаруй аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдсэн байна. 1999-2000 онуудад эдгээр газруудын тоо 376-332 байснаас байнгийн ажилтай нь 136-145 байжээ.

I. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Аж үйлдвэрийн салбарын статистикт дараах ойлголт, тодорхойлолтыг ашигладаг. Үүнд:

Ойлголт	Тодорхойлолт
Нийт үйлдвэрлэл	Тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ.
Завсрын хэрэглээ	Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн эцсийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ.
Нэмэгдэл өртөг	Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ. Нийт үйлдвэрлэлийн үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ.
Бүтээгдэхүүний борлуулалт	Тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.
Аж үйлдвэрийн борлуулалт	Зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.
Үндсэн үнэ	Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.

Үйлдвэрлэгчийн үнэ	Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татвар (нэмэгдсэн өртгийн татвараас бусад) болон тээвэр, худалдааны нэмэгдлүүдийг нэмж, татаасыг хасаж тооцсон үнийг хэлнэ.
Зах зээлийн үнэ буюу худалдан авагчийн үнэ	Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг хэлнэ.
Бүтээгдэхүүн	Үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.
Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл)	Зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.
Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.
Ажиллагч	Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Ажил эрхлэлттэй холбоотой ойлголт, тодорхойлолт нь хөдөлмөрийн статистикт ашигладаг ойлголт, тодорхойлолттой адил байна.
Ажилласан цаг	Тайлант хугацаанд ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ.
Үйлдвэрлэлийн индекс	Үнийн өөрчлөлтийн нөлөөллийг арилгасан биет хэмжээний өөрчлөлтийг илэрхийлэх индексийг хэлнэ.
Улирлын нөлөөллийг арилгах	Хугацааны цуваан дахь улирлын шинж чанартай нөлөөллийг арилгах статистик арга юм.
Цахилгааны тэнцэл	Үйлдвэрлэсэн, импортоор авсан цахилгаан эрчим хүчний нийлбэртэй тэнцүү байна. Цахилгааны тэнцлийг биет хэмжээгээр тооцно. Үйлдвэрлэл + Импорт = Дотоод хэрэглээ + Түгээлт + Шугамын болон түгээлтийн алдагдал + Экспорт
Дулааны тэнцэл	Үйлдвэрлэсэн, импортоор авсан дулааны эрчим хүчний нийлбэртэй тэнцүү байна. Дулааны тэнцлийг биет хэмжээ (мян.Гкал)-гээр тооцно. Үйлдвэрлэл + Импорт = Дотоод хэрэглээ + Түгээлт + Шугамын болон түгээлтийн алдагдал + Экспорт
Нүүрсний тэнцэл	Оны эхний үлдэгдэл, тухайн жилд олборлосон нүүрсний нийлбэртэй тэнцүү байна. Олборлосон нүүрсний тэнцлийг биет хэмжээгээр тооцно. Оны эхний үлдэгдэл + Олборлолт = Борлуулалт + Дахин боловсруулах үйлдвэрт өгсөн нүүрс + Экспорт + Тээвэрлэх, хадгалах үеийн хорогдол + Оны эцсийн үлдэгдэл

II. ХАМРАХ ХҮРЭЭ

Аж үйлдвэрийн салбарын богино хугацааны (сарын) мэдээг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-3.1)-т, урт хугацааны (жилийн) мэдээг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-4.0)-ын дагуу уул уурхай, олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа гэсэн 4 дэд салбарыг хамруулан авч үздэг.

Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцохдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг үндсэн буюу үйлдвэрлэгчийн үнээр тооцдог бөгөөд бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг мөн үнэлж тусгадаг. Нийт үйлдвэрлэлээс бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан зардлын хэмжээг хасаж, тайлант хугацаанд шинээр бий болсон нэмэгдэл өртгийн хэмжээг дэд салбаруудаар тооцож байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тайлан болон холбогдох захиргааны статистик мэдээлэл болно. Мэдээллийг сарын болон жилийн давтамжтайгаар цуглуулж, холбогдох тооцооллыг хийдэг.

Сарын давтамжтайгаар: “Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ”-ний маягтаар аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын гүйцэтгэлийг биет хэмжээ, үнийн дүнгээр тухайн сарын болон жилийн өссөн дүнг цуглуулдаг. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг оны үнээр, бүтээгдэхүүний борлуулалтыг, үүнээс гадаад, дотоодын борлуулалт, нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний тухайн сард борлогдоогүй үлдэгдэл, ажиллагчдын тоо, ажилласан цаг зэрэг үзүүлэлтийг тооцдог.

Жилийн давтамжтайгаар: “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ”, “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хураангуй мэдээ” гэсэн маягтаар тухайн ААНБ-ын орлого, зарлагын дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг тооцож байна.

“Цахилгаан эрчим хүчний баланс”, “Дулааны эрчим хүчний баланс”, маягтаар цахилгаан, дулааны станцуудаас мэдээллийг цуглуулан авч үйлдвэрлэсэн болон импортоор авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ, цахилгаан станцын дотоод хэрэглээ, түгээлтийн болон шугамын алдагдал, хуваарилалт зэрэг үзүүлэлтээр цахилгаан, дулааны эрчим хүч тэнцлийг байгуулдаг.

III. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Манай аймагт 2019 оны байдлаар 2385 бүртгэлтэй ААНБ байгаагийн 1737 буюу 72.8 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 207 буюу 11.9 хувь нь аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа эрхэлж байна. Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 2 буюу 1 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 188 буюу 90.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 17 буюу 8.2 хувь нь цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамжийн салбарт ногдож байна.

ЗУРАГ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбар, хувиар

15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2019 оны байдлаар 50237 байгаагийн 5403 буюу 10.8 хувь нь аж үйлдвэийн салбарт ажиллаж байна. Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын 1861 буюу 34.4 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 875 буюу 16.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 2667 буюу 49.4 хувь нь цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамжийн салбарт ажиллаж байна.

ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, дэд салбар, мянган хүнээр



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 онд 19.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт үйлдвэрлэлийн 15.2 хувийг уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар, 79.2 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 5.6 хувийг ус хангамж, бохир ус зайлуулах системийн үйл ажиллагааны дэд салбарууд тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, мянган төгрөгөөр

Салбараар	2017	2018	2019
Бүгд	**13731185.3**	**28214066.9**	**19732430.8**
Нүүрс олборлолт	1826355.3	3779655	3029629.5
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	2786726.5	7187993.7	6148879.6
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	-	3941044	963946
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5086894.0	5897084.9	6221218.6
Нэхмэлийн үйлдвэрлэл	3693742.9	6181072.3	2157028
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	4900.0	-	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	60690.0	-	-
Мод, модон эдлэл	226310	159822	58118
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	15417.6	21385.5	19399.3
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	25026.0	-	-
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	5123.0	2740.6	19020
Ус ариутгал, усан хангамж	-	1043268.9	1115191.8

Сүүлийн 10 жилийн салбарын нийт үйлдвэрлэлийг харахад 2009-2016 он хүртэлх жигд өсөлттэй, 2017, 2019 онд бууралттай, 2018 онд үйлдвэрлэл хэт өссөн нь мах боловсруулан экспортлох үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, оноор, сая.төгрөгөөр



Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох талх, нарийн боов, ундаа, архи, чихэр, дулаан, гурил бүтээгдэхүүнүүдийг өөрсдөө үйлдвэрлэж аймгийнхаа дотоодын хэрэгцээг хангадаг. Харин цахилгааны хувьд 100% Орхон аймгаас хараат байдаг Завхан аймгийг нүүрсээр хангадаг болно. Манай аймаг аялал жуулчлалын гол бүс нутаг тул гадаад, дотоодын жуулчид иргэдийн хийсэн гар урлалын бүтээгдэхүүнүүдийг сонирхон авдаг.

ХҮСНЭГТ 2. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	АУ-н гол нэр төрлийн бүтээгдэхүүн					
		2015	2016	2017	2018	2019	2019/2018
Түгээсэн ус	мян.м.куб	138.4	95.7	-	214.1	208.2	97.2
Нүүрс	мян.тн	60.8	43.3	55.3	114.5	80.3	70.1
Зүсмэл	мян.м3	1.9	0.7	1.7	0.5	0.2	40.0
Дэр	мян.ш	2.4	4.2	1.5	1	1	100.0
Монгол дээл	ш	261	265	43	66	95	143.9
Савхин гутал, ботинк	хос	72	29	569	-	-	-
Монгол гутал	хос	2	-	5	-	-	-
Буриад гутал	хос	625	122	92	31	47	151.6
Махан консерв	тн	46.3	41.7	3.9	4.3	2.4	55.8
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	тн	17.1	82	-	-	-	-
Малын тэжээл	мян.тн	1.4	0.6	0.7	2.1	-	-
Тараг	мян.л	7.9	7.8	4.7	1.1	1.4	127.3
Талх	тн	1273.6	1169.6	686.3	569.6	495.9	87.1
Жигнэмэг	тн	7.6	11.4	38.3	15.7	240.6	1532.5
Нарийн боов	тн	838.3	896.8	736.4	811.5	486.7	59.9
Жүүс	мян.л	11.5	23.4	18.6	15.8	15.1	95.5
Архи	мян.л	-	-	38.7	46.5	32.6	70.1
Чихэр	тн	3.8	4.4	2.3	1.1	1.3	118.2
Гурил	тн	5237.3	3062.7	3170.1	7373.9	6263.9	84.9
Хэрчсэн гурил	тн	53.1	161.2	0.1	-	98.4	-
Цай	кг	29830.9	24842.3	25457.4	52469.4	65633.0	125.1
Маягт	мхдх	202.4	184.7	50.9	69.6	63.4	91.1

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт 2019 онд 20.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт борлуулалтын 3.1 тэрбум төгрөг буюу 15.1 хувийг уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар, 16.3 тэрбум төгрөг буюу 79.5 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 1.1 тэрбум төгрөг буюу 5.4 хувийг ус хангамжийн дэд салбар эзэлж байна. Нийт борлуулалт өмнөх оны мөн үеэс 5.5 тэрбум төгрөг буюу 21.4 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, сая төгрөгөөр

Салбараар	2017	2018	2019
Бүгд	**14227607.8**	**26124544.9**	**20560895.4**
Нүүрс олборлолт	2489889.2	4323209.1	3100735.9
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	2530076.5	6984623.8	6039983.1
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	-	4416724.8	1573943.5
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5174849.9	6007808.7	6343677.8
Нэхмэлийн үйлдвэрлэл	3690013.2	3164242.7	2257372.4
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	4900.0	-	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	60690.0	-	-
Мод, модон эдлэл	230845.0	160237	58118
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	15838.0	21385.5	19399.3
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	25026.0	-	-
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	5480.0	2744.4	19020
Ус ариутгал, усан хангамж	-	1043568.9	1148645.4

IV УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭР

Уул уурхай, олборлох үйлдвэрийн дэд салбар нь аж үйлдвэрийн салбарт томоохон хувийн жин эзэлдэг чухал салбар юм. Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэр төрлөөр буюу олон улсын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0-р дараах 5 дэд салбарт ангилна.

- Нүүрс олборлолт
- Газрын тос олборлолт
- Металлын хүдэр олборлолт
- Бусад ашигт малтмал олборлолт
- Уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагаа

IV.1 НҮҮРС ОЛБОРЛОЛТ

Хөвсгөл аймагт нүүрсний борлуулалт 2019 онд 3100.7 сая төгрөг болж, өмнөх оноос 28.3 хувиар буурсан байна. Аймгийн нүүрсний нийт олборлолт 2019 онд 80.3 мян.тн болж өмнөх оны мөн үеэс 29.8 хувиар буурсан байна.

ЗУРАГ 4. Нүүрс олборлолт / мян.тн /, 2010-2019 он



V. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ

Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт дараах дэд салбаруудыг багтаан авч үздэг.

• Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
• Ундааны үйлдвэрлэл
• Тамхи үйлдвэрлэл
• Нэхмэлийн үйлдвэрлэл
• Хувцас үйлдвэрлэл
• Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
• Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл
• Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
• Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа
• Кокс болон газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүний үйл ажиллагаа
• Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
• Эм, эм бэлдмэл, химийн болон ургамлын гаралтай эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
• Резин болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл
• Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл
• Металл үйлдвэрлэл
• Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүний үйлдвэрлэл
• Компьютер, электроник болон хараа зүйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
• Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл
• Дээрх дэд салбарт ороогүй бусад машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэл

• Моторт авто тээврийн хэрэгсэл, чиргүүл, хагас чиргүүл үйлдвэрлэл
• Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл
• Тавилга үйлдвэрлэл
• Бусад боловсруулах үйлдвэрлэл
• Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар үйлчилгээ

V.1 ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ

Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувийн жин 2019 онд 67.5 хувь байна. Хүнсний салбарын нийт үйлдвэрлэлт 13.3 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбар нь дараах дэд бүлгээс бүрддэг.

1. Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт
2. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
3. Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл
4. Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл
5. Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/

V.1.1 Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн малын махны хэмжээ 2019 онд 157.4 тонн болж, өмнөх оноос 845.4 тонн буюу 6.4 дахин буурсан байна. Махан нөөшийн төрлийн бүтээгдэхүүн 2019 онд 2.4 тонн болж өмнөх оноос 1.9 тонн буюу 44.2 хувиар буурсан байна.

V.1.2 Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Манай аймаг сүү, сүүн бүтээгдэхүүний ихэнх хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Тараг 1.4 мянган литр болж 0.3 мянган литр буюу 27.3 хувиар, өрөм, зөөхий 1.2 тонн болж 0.2 тонн буюу 20 хувиар, ааруул 5.6 тонн болж 2.9 тонн буюу 1 дахин өссөн бол, аарц 0.3 тонн болж 1.6 тонн буюу 84.2 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 4. СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2019
Тараг	мян.л	7.9	7.8	4.7	1.1	1.4
Ааруул	тн	11.7	14.4	8.0	2.7	5.6
Өрөм, зөөхий	тн	1.5	2.9	1.5	1.0	1.2
Аарц	тн	2.2	2.4	2.4	1.9	0.3

V.1.3 Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь хүн амын өргөн хэрэглээний бүтээгдэхүүний нэг бөгөөд сүүлийн жилүүдэд гурилын хэрэгцээний ихэнх хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. 2019 онд 6263.9 тонн гурил үйлдвэрлэсэн бөгөөд үүний 6200.8 тонн буюу 99 хувийг нэгдүгээр зэргийн гурил, 63.1 тонн буюу 1 хувийг хоёрдугаар зэргийн гурил тус тус эзэлж байна.

ЗУРАГ 5. ГУРИЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрөл, мянган тонноор



Аймгийн талх, нарийн боовны нийт үйлдвэрлэлт 2011 онд 1194.9 тн байсан бол 2019 онд 982.6 тн болж, 2011 онтой харьцуулахад 17.7 хувь, харин өмнөх оноос 28.9 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 6. ТАЛХ, НАРИЙН БООВНЫ ҮЙЛДВЭРЛЭЛТ / тн /, 2011-2019 он



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Ардын хувьсгал ялахаас өмнө Хөвсгөлийн хязгаар нутагт гадаадын худалдаа, мөнгө хүүлэгч 100 гаруй салбар пүүс ажиллаж байв. Хувьсгалын дараа 1921 оны сүүлчээр Ардын харилцан туслалцах хоршоог анх байгуулж, 1922 оны эхээр Хатгалд ард иргэдэд үйлчлэх худалдааны салбар байгуулагдсан нь тус аймагт худалдааны байгууллага буй болох үндэс суурь болсон байна. Анхны хоршоог эд бараагаар хангах гэж 30 гаруй тэмээн жингээр 79 мянган лан мөнгөний үнэ бүхий цай, даалимба, цуу ямбуу, дүнсэн тамхи зэрэг эд бараа ачин авчирч байжээ.

Хоршооны салбар хөдөө орон нутагт байгуулагдаж байсны дотор Мөрөнгийн хүрээнд 1923 онд салбар байгуулагдаж, Сар толгой, Жалханз, Бүгсийн хүрээнд жижиг дэлгүүр нээгджээ. 1927 онд хоршооны салбар 7 болж 373 мянган төгрөгийн бараа борлуулж, 300 гаруй мянган төгрөгийн ноос, түүхий эд цуглуулан авсан байна.

1931 онд аймаг байгуулагдсаны дараа хоршооны салбарын тоо 15-д хүрч, худалдаа наймааны эргэлт ихсэж, ард иргэд бэлтгэлийн зүйлээ дэлгүүр хоршоонд өгөх нь нэмэгдсэн. 1934 онд Монгол Оросын хамтарсан центрсоюз хэмээх худалдааны байгууллагын суурин дээр аймгийн хоршоодын холбоо байгуулагдсан. 1940 он болоход Хоршоодын холбооны харьяанд анхны хоршоо 15, сумын салбар хоршоо 6, дэлгүүр 43, агент, ганзагын наймаа хийгчдийн тоо 538-д хүрч, бараа гүйлгээ 5.3 сая төгрөг болж, 2.1 сая төгрөгөөр бэлтгэлийн зүйл худалдан авч байв.

Аймгийн хоршоодыг холбоог 1958 онд өөрчлөн байгуулж, худалдаа бэлтгэлийн ангитай болсон. Худалдааны байгууллагын хүрээ өргөсөн номын худалдаа, бөөний худалдааны бааз, нийтийн хоолны газар байгуулагдаж, иргэдэд үйлчлэх үйлчилгээ нь улам өргөн болж материаллаг бааз сайжирсан юм.

1980-аад онд аймгийн худалдааны байгууллага бараа, түүхий эдийн 156 агуулах, мах ногооны 37 зоорь, төрөл бүрийн үйлчилгээний зориулалтын 50 шахам машин трактортай, худалдааны мэргэжилтэй боловсон хүчин, мэргэшсэн ажилчдаар хангагдсан байлаа.

1990-ээд оны эхнээс төвлөрсөн хангамжийн тогтолцоо задарч, худалдаа үйлчилгээний бүх байгууллага хувьчлагдаж, зах зээлийн шинэ орчин бий болж, үйлчилгээний шинэ хэлбэрт шилжсэн. Өнгөрсөн 20 шахам жилд зах зээлийн үеийн худалдаа, үйлчилгээний шинэ хэлбэр бүрэлдэн тогтож, худалдаа, түүхий эд бэлтгэл, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээг бүрэн хувийн хэвшлийнхэн гүйцэтгэх болсон.

VI. ХУДАЛДААНЫ САЛБАР

Аймгийн худалдааны нийт борлуулалт 2015 онд 41.9 тэрбум байсан бол 2017 онд 156.6 тэрбум төгрөг болж, 3 дахин, өмнөх оноос 18.5 хувиар өссөн байна.

ЗУРАГ 7. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, /тэрбум. төг/, 2015-2019 оН



2019 оны байдлаар аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий хүнсний 500 дэлгүүр, үйлчилгээний 118 цэг үйл ажиллагаа явуулж байна. Мөрөн сумын хэмжээнд 216 согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг, 34 бөөний худалдаа, 5 зах, 35

хүнсний бус барааны дэлгүүр, 1 их дэлгүүр, 12 супермаркет, 6 авто засвар, автомашин угаалга 5, дугуй засвар 8, гэр ахуйн цахилгаан барааны засвар 2, зочид буудал 15, зоогийн газар 85 ажиллаж байна.

ХҮСНЭГТ 5. СОГТУУРУУЛАХ УНДААГААР ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЦЭГ, сумаар, 2019 он

Сумын нэр	Нийт	Худалдаа	Үйлчилээ
Бүгд	**618**	**500**	**118**
Алаг-Эрдэнэ	7	6	1
Арбулаг	7	7	-
Баянзүрх	13	11	2
Бүрэнтогтох	15	9	6
Галт	21	21	-
Жаргалант	15	12	3
Их-Уул	19	17	2
Рашаант	9	9	-
Рэнчинлхүмбэ	16	14	2
Тариалан	17	11	6
Тосонцэнгэл	16	11	5
Төмөрбулаг	22	20	2
Түнэл	15	12	3
Улаан-Уул	9	9	-
Ханх	10	9	1
Цагаан-Уул	16	14	2
Цагаан-Үүр	11	9	2
Цэцэрлэг	14	13	1
Чаньдмань-Өндөр	17	10	7
Шинэ-Идэр	8	7	1
Хатгал	69	34	35
Мөрөн	250	216	34
Цагааннуур	9	7	2
Эрдэнэбулган	12	11	1

VII. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр Хөвсгөл аймгийн ДНБ-ны 29.8 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 26.4 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн байна. Энэ нь өмнөх оноос аж үйлдвэр, барилга 0.7 пункт, үйлчилгээний салбар 1.5 пунктээр тус тус буурсан байна.

ЗУРАГ 8. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ



VIII. ДҮГНЭЛТ

Манай аймагт 2019 оны байдлаар 2385 бүртгэлтэй ААНБ байгаагийн 1737 буюу 72.8 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 207 буюу 11.9 хувь нь аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа эрхэлж байна.

15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2019 оны байдлаар 50237 байгаагийн 5403 буюу 10.8 хувь нь аж үйлдвэйин салбарт ажиллаж байна. Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын 1861 буюу 34.4 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 875 буюу 16.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 2667 буюу 49.4 хувь нь цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамжийн салбарт ажиллаж байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 онд 19.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт үйлдвэрлэлийн 15.2 хувийг уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар, 79.2 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 5.6 хувийг ус хангамж, бохир ус зайлуулах системийн үйл ажиллагааны дэд салбарууд тус тус эзэлж байна.

2019 оны байдлаар аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий хүнсний 500 дэлгүүр, үйлчилгээний 118 цэг үйл ажиллагаа явуулж байна. Мөрөн сумын хэмжээнд 216 согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг, 34 бөөний худалдаа, 5 зах, 35 хүнсний бус барааны дэлгүүр, 1 их дэлгүүр, 12 супермаркет, 6 авто засвар, автомашин угаалга 5, дугуй засвар 8, гэр ахуйн цахилгаан барааны засвар 2, зочид буудал 15, зоогийн газар 85 ажиллаж байна.

2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр Хөвсгөл аймгийн ДНБ-ны 29.8 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 26.4 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн байна. Энэ нь өмнөх оноос аж үйлдвэр, барилга 0.7 пункт, үйлчилгээний салбар 1.5 пунктээр тус тус буурсан байна.

Ашигласан материал

1. Хөвсгөл аймгийн нийгэм,эдийн засгийн танилцуулга 2009-2019 он
2. Сарын аж үйлдвэрийн мэдээ
3. Монгол улсын статистикийн эмхтгэл
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn